



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/766.

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11/02 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 113, 241 дүгээр тогтоолоор Мянгад сумын Ерөнхий боловсролын сургуульд шилжүүлсэн 2 автомашиныг Орхон аймгаас шилжүүлэн татан авахад гарсан шатахуун, тосолгооны материалын зардалд 2000.0 мянган төгрөг /хоёр сая/-ийг зарцуулсугай.

2. Шатахуун тосолгооны материалын үнэд зарцуулах 2000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ